



СОЁЛЫН ЯАМ

КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

**Улаанбаатар хот
2024 он**

КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон Соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРАУ /хувийн эрх зүйн нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу тооцлоо.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт заасан журмын дагуу төрийн байгууллагын зардал, хуулийн этгээд, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

1. КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮССЭН ЗАРДАЛ

- Конвенцын хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй ажилтны тогтвортой орон тоог бий болгох,
- Монгол Улсаас Хууль бусаар экспортлогдсон, хулгайлагдсан соёлын эд зүйлсийн судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх.

1.1. Конвенцын хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй ажилтан, түүнд зарцуулагдаж буй зардал.

Монгол Улсын Үндсэн хуулийн Долоодугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.

2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.5.9-д "Хилийн чанад дахь монгол соёлын өвийг сурвалжлан олох, судлах, нэгдсэн каталог хийх, эх орондоо эргүүлэн залах чиглэлээр бусад улс оронтой идэвхтэй хамтран ажиллана" гэж, 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан "Соёлын тухай" хуулийн /шинэчилсэн найруулга/ 27.1.1-д "монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, хадгалж хамгаалах талаар уг өв байгаа улстай хамтран ажиллах"; 27.1.2-д "монголын түүх, соёлд холбогдох соёлын үнэт зүйлийн хуулбарыг авчрах"; 27.1.3.-д "хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах" гэж тус тус заасан.

Конвенцын хэрэгжилтийг хангахад олон улсын эрх зүй, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсаас хууль бусаар экспортлогдсон, хулгайлагдсан соёлын эд зүйлсийг судлах, бүртгэх, эх оронд нь эргүүлэн залах ажлыг зохион байгуулах төдийгүй

соёлын үнэт зүйлийн экспорт болон импортын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан гүйцэтгэх орон тооны ажилтан төрийн захиргааны байгууллагын бүтцэд шаардлагатай болохыг тодорхойлж 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдөр байгуулагдсан Соёлын яамны бүтцэд Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрыг 7 орон тоотой байгуулсан. Уг газарт "Дэлхийн болон бүс нутгийн өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн" орон тоог ТЗ-7 зэрэглэлээр 1.597.000 төгрөгийн цалинтай баталсан.

1.2. Монгол Улсаас хууль бусаар экспортлогдсон, хулгайлагдсан соёлын эд зүйлсийн судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх.

Конвенцын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Соёлын яамнаас соёлын өвийн мэдээллийн системийг боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд "Ай Си Ти групп" ХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр "Соёлын өвийн улсын нэгдсэн, бүртгэл мэдээллийн системийн хөгжүүлэлт хийх" СОЯ/202209046 дугаар зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, уг системд хилийн чандад байгаа монголын соёлын эд зүйлсийн судалгаа мэдээллийн сан бүрдүүлэхээр оруулсан.

Монгол Улсаас хууль бусаар экспортлогдсон, хулгайлагдсан соёлын эд зүйлсийг эх орондоо эргүүлэн залах эсхүл хуулбарлан авах ажлыг үе шаттай тогтвортой хэрэгжүүлэхэд судалгаа мэдээллийг бааз/ дата бүрдүүлэх шаардлага юм. Судлах сан бүрдүүлэх ажлыг 1992 онд Соёлын яам байгуулагдаж гадаад оронд суугаа элчин сайдаараа дамжуулан хэрэгжүүлэхээр ажиллаж эхэлсэн байдаг. 1995 онд Соёлын өвийн үндэсний төв байгуулагдан, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэн үндсэн чиг үүргийнхээ хүрээндээ "гадаадад халин гарсан түүх, соёлын дурсгалыг бүртгэх" ажлыг хариуцсан. Гэвч үйл ажиллагаа хангалттай хэрэгжиж чадаагүй.

2020 онд Соёлын яам байгуулагдсаар гадаадад байгаа монголын өвийг судлах ажилд анхаарал хандуулснаар тодорхой үр дүнд хүрээнд байна. Үүнд, ЮНЕСКО-гийн "Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" 1970 оны конвенцид Монгол Улс 1991 онд элсэн орсон. Уг конвенцын хэрэгжилтийг хангахад ЮНИДРУА-гийн конвенцод нэгдэн орох явдал нэн чухал болохыг санаж 2022 оноос тандалт судалгааны ажил хийгдэж эхэлсэн. Соёл, урлагийг дэмжих сангийн 2023 оны төсөл арга хэмжээний дотор "Хилийн чандад буй Монголын соёлын өвийн цахим мэдээллийн сан бүрдүүлэх нь" сэвдээр "Монголын соёлын сүлжээ, харилцаа холбооны зөвлөл" ТББ төсөл бичиж Швед улсын утсаатны зүйн музейд хадгалагдаж байгаа Монголын дурсгалын бүртгэлийн сан бүрдүүлж, 11 мянган дурсгалын бүртгэлийн сан үүсгэн Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэн өглөө. Академич С.Чулуун гадаад орон байгаа монголын дурсгалын судалгааг 2014 оноос эхлүүлж, 15 оронд байгаа монголын холбогдох дурсгалыг илрүүлэн судалж, тухай орны холбогдох Засаг захиргааны нэгжээс зөвшөөрөл авч 11 боть номыг улсын төсвөөр хэвлүүлсэн.

Гадаадад байгаа халин гарсан монголын дурсгалыг бүртгэх, ямар учир шалтгаанаас гарсан эх сурвалжийг судлан тогтоох ажил гүйцэтгэх орон тоог Соёлын өвийн үндэсний төв, Чингис хаан Үндэсний музей тусгайлсан орон тоо байхгүй ч чиг үүргийнхээ хүрээнд бүтэц орон тоондоо багтаан шийдвэрлэж байна. Тодруулбал, Уг

ажлыг Бүртгэл мэдээллийн санч, Эрдэм шинжилгээний ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгасан чиг үүрэгт хамруулан гүйцэтгэж байна.

Уг сангийн талаарх статистикийн мэдээллийг соёлын үйл ажиллагаа эрхлэгч нь жил бүр гаргаж өгөх бол статистик гаргахтай холбогдон гарах зардал гарна. Үүнд хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу ажилтан эсвэл иргэний үүсэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн цаг хугацаа болон тооцооллын аргачлалыг ашиглалаа.

Д/д	Ажлын нэр	Гүйцэтгэх хугацаа (минут)
1	Үүрэгтэй танилцах	20
2	Мэргэжлийн зөвлөгөө авах (холбогдох газраас)	80
3	Мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллийг нэгтгэх	120
4	Цуглуулсан мэдээллээ боловсруулах (нягтлах, тооцоолох, шалгах гэх мэт)	60
5	Маягт бөглөх	25
7	Мэдээллээ холбогдох газарт илгээх	20
9	Баримт бичиг хуулбарлах үдэх, хадгалах	10
11	Эрх бүхий байгууллагаас нэмэлт лавлагаа шаардвал гаргаж өгөх	60
Нийт		395

Ажилтан статистикийн мэдээллийг гаргахад ойролцоогоор 395 минут буюу 7 цаг орчмын хугацаа зарцуулна. Үүний дагуу ажлын үнэлгээ болон холбогдох маягт, тодорхойлолтын төлбөрийг тооцооллоо.

Зориулалт	Хэмжих нэгж	Зардал /төгрөгөөр/
Зарцуулах цагийн гүйцэтгэлийн зардал	7 цаг	13,328
Бичиг хэргийн зардал:		
Бичиг баримт боловсруулах	1 ширхэг	250
Баримт бичиг хуулбарлах	6 ширхэг	900
Нийт		14,478.0

Тайлбар: нэг хүний цагийн хөлс нь өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж буй эрх зүйн хүрээнд 1904 төгрөг. /хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр/

2. КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮССЭН ЗАРДАЛ

Хуулийн төсөлтэй холбоотой иргэн хуулийн этгээдээс зардал гарахгүй.

3. ХУУЛИЙГ СУРТАЛЧЛАХ, КОНВЕНЦЫН ТАЛААРХ МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛЭХЭД ЧИГЛЭГДСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх, соёлын үнэт зүйлийн хууль бус худалдаатай тэмцэх чадавхыг дээшлүүлэх-конвенцын талаарх мэдлэг ойлголтыг түгээх сургалтыг 2 үе шаттай зохион байгуулахаар тооцов.

Үе шат	Хамрагдах байгууллага	Давтамж	Сургалтад шаардагдах зардал /сая, төг/	Нийт зардал
I үе шат	Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, хууль хяналт, оюуны өмчийн байгууллага /20 хүн/	Жилд нэг удаа	Сургалтад 2.500.000 ₮	16.350.000 ₮
II үе шат	Орон нутгийн соёлын ажилтныг чадавхжуулах сургалт -Аймаг, нийслэлийн Соёл урлагийн ажилтан /45 хүн/	Жилд нэг удаа	Улаанбаатар хотод ирэх, буцах зардал /ойролцоогоор 45x250,000 / 11.250.000 ₮ Сургалтад 2.600.000 ₮	

НИЙТ ЗАРДАЛ

Хугацаа	Төрийн захиргааны албан хаагчийн цалин	Бүртгэл мэдээллийн сангийн статистик мэдээлэл бэлтгэх	Конвенцын мэдлэг ойлголтыг түгээх сургалт	Нийт зардал
1 жилд	1.597.000 ₮ x 12 сар =19.164.000 ₮	14,478.0 ₮ x 2 удаа =29560 ₮	16.350.000 ₮	35,543,560 ₮

Конвенцыг соёрхон батлах буюу нэгдэн ороход улсын төсвөөс олон улсын гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ хийх, томилолтоор ажиллах, төлөөлөгчид хүлээн авах, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, олон улсын гэрээ байгуулах, олон улсын гэрээнд нэгдэн орохтой холбоотой судалгаа хийх, олон улсын гэрээг орчуулах, орчуулгыг хянан баталгаажуулах, олон улсын гэрээний тусгай хэвлэмэл хуудас, хавтас, үдээс, лац захиалах урсгал зардал гарах бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд захиргааны ачаалал, нэмэлт зардал үүсгэхгүй. Мөн гэрээний хэрэгжилтийг тайлагнах шаардлагагүй ба цаашид конвенцыг ашиглан соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаан авах нийгмийн үр өгөөж гарах зардлаас ямагт өндөр тусна.